

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДАН ГАРСНААР
ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

2026 он

Агуулга

Нэг.Ерөнхий үндэслэл	2
Хоёр.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо:	3
2.1.Шүүхийн мэдэгдэх хуудас хүргэх зардлын хэмнэлт	3
2.2.Шүүхийн ачааллыг бууруулах, хяналтын шатны шүүхийн зардал.....	4
2.3.Хэрэг шилжүүлэхтэй холбоотой зардал.....	4
Гурав.Хуулийн этгээд, иргэдээс гарах зардлын тооцоо.....	4
3.1.Цаг хугацааны болон өмгөөллийн зардлын хэмнэлт	5
Дөрөв.Зардлын тооцооны нэгдсэн дүгнэлт	5

Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу хуулийг баталснаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог гаргав.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын гаргаж байгаа зардлыг тооцож, цаашид ачааллыг багасгах санал боловсруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

Хоёр.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо:

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллага буюу шүүхийн үйл ажиллагаанд нэмэлт зардал үүсэхгүй бөгөөд урсгал зардлыг хэмнэх, шүүхийн үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх эерэг үр дагавар үүснэ гэж үзэж байна.

2.1.Шүүхийн мэдэгдэх хуудас хүргэх зардлын хэмнэлт

4 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн ... 75⁴ дүгээр зүйлийн 75⁴.4 дэх хэсгийн “бол мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцно.” гэснийг “боловч шүүхэд ирээгүй бол шүүхийн албан ёсны цахим хуудсаар нэхэмжлэгч, хариуцагчийн нэр, овог, нэхэмжлэлийн шаардлага болон хувийн ба үндэсний цахим шуудангийн хаягаар нь мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн тухай дурдан, шүүхэд хүрэлцэн ирж эрхээ хамгаалахаар ажиллагаанд оролцохыг зарлан мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдсэнээс хойш 7 хоног өнгөрсөн бол мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцож хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулна.” ... гэж тус тус өөрчилсүгэй.

Одоогийн байдлаар шүүхээс мэдэгдэх хуудсыг шуудангаар болон биечлэн хүргүүлэхэд ихээхэн зардал гардаг бөгөөд үр нөлөө багатай, үндэсний цахим шуудангаар мэдэгдэхэд асуудал үүсэж буй талаар тус хуулийн төслийн үзэл баримтлалд тусгажээ. Шүүхийн албан ёсны цахим хуудсаар нэхэмжлэгч, хариуцагчид мэдэгдэх хуудас хүргүүлсэнд тооцсоноор тус ажиллагааг аль болох богино хугацаанд, хэргийн оролцогчийг чирэгдүүлэлгүй, хүндрэл багатай явуулах боломжтой болно.

Иймд биечлэн мэдэгдэх хуудсыг шуудангаар болон биечлэн хүргүүлэхэд гарах зардал буурж, шүүхийн тамгын газрын ажлын ачааллыг багасгана. Шүүхийн цахим хуудсанд мэдээлэл байршуулах нь одоогийн байгаа систем дээр хийгдэх тул нэмэлт төсөв шаардахгүй.

¹ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн

2.2.Шүүхийн ачааллыг бууруулах, хяналтын шатны шүүхийн зардал

3 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75¹¹ дүгээр зүйлийн 75¹¹.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“75¹¹.2.Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүх эцэслэн шийдвэрлэх ба хяналтын журмаар гомдол гаргахгүй.”

15 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх хэргүүд Улсын дээд шүүхээр хянагдахгүй болсноор дээд шүүхийн шүүгч, ажилтнуудын ачаалал буурч, төсвийн зардлыг хэмнэнэ.

2.3.Хэрэг шилжүүлэхтэй холбоотой зардал

1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулга бүхий зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалт:

“20.1.4.энэ хуулийн 75⁷.1-д заасан үндэслэл тогтоогдсон бол.”

4 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн ... 75⁷ дугаар зүйлийн 75⁷.1 дэх хэсгийн “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ.” гэснийг “энэ хуулийн 20.1.4-т заасны дагуу өөр шүүхэд шилжүүлж болно.” гэж, 75⁷ дугаар зүйлийн 75⁷.3 дахь хэсгийн “байна.” гэснийг “байх боловч шилжүүлсэн хэргийг хүлээн авсан шүүх шаардлагатай гэж үзвэл товыг өөрчлөн тогтоож болно. Тов өөрчилсөн шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй.” гэж тус тус өөрчилсүгэй.

Энэ нь шүүхүүдийн ачааллыг тэнцвэржүүлэх зохицуулалт тул нэмэлт зардал гарахгүй, харин шүүхийн нөөцийг оновчтой хуваарилах боломжийг бүрдүүлнэ.

Гурав.Хуулийн этгээд, иргэдээс гарах зардлын тооцоо

Аргачлалын дагуу иргэнд үүрэг болгосон зохицуулалт буюу хуулиар заавал биелүүлэх ёстой үйл ажиллагааг хуулийн төслөөс олж тогтоох учиртай.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй...” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг

бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тус тус хуульчилсан.

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2.7-д “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх, иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл, компани, шударга өрсөлдөөн, монополь, хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж заасан.

Тус зохицуулалтуудын хүрээнд дараах хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төсөл нь иргэн, хуулийн этгээдэд шинээр татвар, хураамж бий болгоогүй тул санхүүгийн шууд дарамт учруулахгүй. Харин дараах байдлаар шууд бус зардлыг хэмнэх боломжтой байна. Үүнд:

3.1.Цаг хугацааны болон өмгөөллийн зардлын хэмнэлт

Тусгайлсан журмаар шийдвэрлэх хэргийн босго хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй буюу 15,840,000 төгрөг байсныг 15 сая төгрөг болгон бууруулснаар хялбар ажиллагааны шүүхийн ачаалал буурах бөгөөд түргэн шуурхай шийдвэрлэх боломж нөхцөл бүрдэнэ. Мөн давж заалдах шатны шүүхээр эцэслэгдэх нь иргэд, бизнес эрхлэгчдийн шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх хугацаа багасаж, тэдгээрээс гарах зардал буурна.

Дөрөв.Зардлын тооцооны нэгдсэн дүгнэлт

Аргачлалын дагуу хийсэн тооцооллоор энэхүү хуулийн төслийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс нэмэлт санхүүжилт шаардагдахгүй. Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахимжилтыг дэмжих, шат дамжлагыг цөөлөх замаар шүүхийн үйл ажиллагааны зардлыг бууруулах, иргэд, хуулийн этгээдийн шүүхэд зарцуулах цаг хугацаа, хөрөнгийг хэмнэх эдийн засгийн эерэг үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.